

5

ЭКСПОРТЫГ БАРИМЖААЛСАН БОДЛОГО УУ, ЭСВЭЛ ИМПОРТЫГ ОРЛОХ БОДЛОГО УУ

Э. Гүргэмжав, Н.Батнасан

Улсын Их Хурал 1996 онд Монгол улсыг 2020 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөгжлийн үзэл баримтлалыг батлахдаа экспортыг баримжаалсан хөгжлийг эдийн засгийн хөгжлийн стратеги чиглэл болгон дэвшүүлсэн юм. Гэвч эдийн засгийн хямрал үргэлжилж, үндэсний үйлдвэрлэлийн зарим салбаруудын уналт гүнзгийрч, төлбөрийн болоод худалдааны тэнцэл алдагдалтай байгаа зэрэг нь экспортыг дэмжих бодлогын хэрэгжилт ямар хэмжээнд байгааг эрхбиш эргэж харах шаардлагатайг хэлээд байна.

Зэрэгцүүлсэн үнээр авч үзвэл, 1995-1999 онуудад Монгол улсын ДНБ 13.53% өссөн байхад таваарын болон үйлчилгээний экспорт 3.14% буурчээ. Мөн хугацаанд дотоодын хэрэглээ 26.96%, таваарын ба үйлчилгээний импорт 28% өссөн байна. Ялангуяа 1998, 1999 оны импортын огцом өсөлт сүүлийн жилүүдэд худалдааны тэнцэл эрс муудах үндсэн шалтгаан нь болсон байна (хүснэгт 1).

Хүснэгт 1

**Монгол улсын макроэдийн засгийн зарим үндсэн үзүүлэлтүүд
1995-1999 онд (1995оны зэрэгцүүлсэн үнээр)**

үзүүлэлтүүд	1995	1996	1997	1998	1999
ДНБ	100.00	102.35	106.44	110.20	113.53
хөрөнгө оруулалт	100.00	105.26	119.10	131.66	152.37
хэрэглээ	100.00	107.89	113.87	123.03	126.96
экспорт	100.00	98.11	96.29	93.65	96.86
импорт	100.00	102.16	104.82	122.50	128.00
инфляц	100.00	144.60	174.20	184.70	203.10

Эх сурвалж: "Монгол улсын статистикийн эмхтгэл" 1995-1999, "Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл" 1995-1999, "Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл"-д тулгуурлан тооцоог хийв.

Судалгаанаас үзэхэд 1999 оны байдлаар гадаад худалдааны алдагдал Монгол улсын ҮНБ-ийг 18.9% бууруулж байв. Дүгнэж үзвэл, экспортын салбарын өнөөгийн хөгжилт нь хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, үндэсний эдийн засгийн хөгжлийн бодит шаардлагатай илт зөрчилдөх болсон байна.

Экспортын бүтцэд ХАА-н болон байгалийн гаралтай түүхий эд материалын экспорт 314-аас илүү хувийг эзэлж байгаа нь дэлхий нийтийн чиг хандлагатай зөрчилдөх байгаа ба 1999 оны байдлаар экспортын 200 гаруйхан нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж байсан нь туйлын чамлалттай үзүүлэлт юм. Экспортлож буй бүтээгдэхүүний нэр төрөл цөөхөн байгаа тул Монгол улс өөрийн орны үйлдвэрлэлийн давуу тал, үйлдвэрлэлийн орцуудаа бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна (хүснэгт 2).

Хүснэгт 2

**Монгол улсын экспортын таваарын бүтэц
1995-1999 онд (%-иар)**

Бүтээгдэхүүний ангилал	1995 он	1996 он	1997 он	1998 он	1999 он
1. ХАА - н бүтээгдэхүүн	22.36	27.55	23.59	25.35	33.81
а/ түүхий эд	21.82	27.14	23.14	24.53	33.10
б/ хүнсний бэлэн бүтээгдэхүүн	0.54	0.41	0.44	0.82	0.71
2. Уул уурхайн ба олборлох үйлдвэрийн бүтээгдэхүүн	65.50	57.22	55.69	45.28	40.98
а/ худар, эрдэс бодис, хар темерлэг	65.32	57.19	55.61	45.03	40.58
б/ бусад хагас боловсруулсан бүтээгдэхүүн	0.18	0.03	0.08	0.25	0.40
3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	12.14	15.23	20.73	29.37	25.21
а/ тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслэл	3.23	1.77	2.37	2.43	3.07
б/ химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	0.35	0.71	0.25	0.11	0.17
в/ бусад хагас боловсруулсан бүтээгдэхүүн	1.44	2.63	5.39	13.03	4.10
г/ нэхмэл сүлжмэл ба хувцас	3.10	6.29	7.68	10.48	15.27
д/ ширэм ба ган					
е/ бусад бэлэн бүтээгдэхүүн	1.26	0.85	2.15	1.42	1.30
Аж үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн	0.25	0.02	0.04	0.04	0.22

Эх сурвалж "Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл 1996, 1997, 1998, 1999"

Худалдааны нөхцөлд хийсэн шинжилгээнээс үзвэл 1995-1999 онд экспортын бараа таваарын үнэ жилд дунджаар 14.1% орчим буурч байхад импортынх 6.9% орчим өсч байлаа. Өөрөөр хэлбэл, энэ хугацаанд экспортын худалдан авах чадвар ийм хэмжээгээр буурч байлаа гэсэн үг.

(хүснэгт 3) Худалдааны орлогын нөхцлийн индексүүд 100-аас бага байгаагаас үзэхэд олон улсын худалдаанд оролцогч худалдааны түнш орнуудтай харьцуулахад орлогын дахин хуваарилалт нь манай орны хувьд ашиггүй байдаар хийгдэж байна. Экспортын бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн уналтаас шалтгаалан Монгол улс үрэлгэн байдалтай экспорт хийж байна. Дэлхийн зах зээл дэх үнийн өсөлтийн одоогийн чиг хандлага угзэлжлэх тохиолдолд экспорт импортын таваарын бутцийг өөрчлөхгүйгээр гадаад худалдаагаа өргөжүүлсэн тохиолдолд худалдааны тэнцэл улам бүр муудах шинжтэй байна.

Хүснэгт 3

**Монгол улсын гадаад худалдааны нөхцөл
1996-1999 онд**

Үзүүлэлтүүд	1995-1996 он	1996-1997 он	1997-1998 он	1998-1999 он
1. экспортын үнийн индекс - Ip_x	81.27	115.62	71.17	88.29
2. экспортын тоо хэмжээний индекс - Iq_x	110.60	90.60	103.48	115.26
3. импортын үнийн индекс - Ip_{im}	108.85	88.13	84.87	93.92
4. импортын тоо хэмжээний индекс - Iq_{im}	97.09	113.78	122.34	101.10
5. таваарын буюу цэвэр бараа огилцироны нөхцөл - Тот	74.66	131.19	83.86	94.01
6. худалдааны орлогын нөхцөл - Т1Т	82.58	118.86	86.78	108.35
7. худалдааны хүчин зүйлийн нөхцөл - Т2Т	85.05	104.46	70.93	107.17

Эх сурвалж "Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл 1995, 1996, 1997, 1998, 1999-д үндэслэн тооцсон экспорт, импортын үнийн индексийн тооцоолыг ашиглав."

Монгол улсын гадаад худалдааны нөхцөл муу байгаагаас төлбөрийн тэнцлийн алдагдал төдийлөн буурахгүй байна. 1998 оны байдлаар төлбөрийн тэнцлийн алдагдал ДНБ-ий 1.7%-тай тэнцэж байв.

Ийнхүү Монгол улсын макроэдийн засгийн болон экспортын үзүүлэлтүүд нь экспортын үйлдвэрлэлийн өнөөгийн байдлыг тоймлон харах бололцоог олгож байгаа юм. Гэвч эдгээр үзүүлэлтүүд нь экспортыг дэмжих бодлогын хэрэгжилт ямар байдалтай байна вэ гэдэгт хариулт өгч чадахгүй юм. Тиймээс зохиогчид макроэдийн засгийн зэрэгцүүлсэн үнээр илэрхийлсэн үзүүлэлтүүдийг ашиглан зарим нэг шинжилгээг хийсэн юм.

Макроэдийн засгийн зэрэгцүүлсэн үнээр илэрхийлсэн үзүүлэлтүүдээс импортын ДНБ-ээс хамаарах функцийг олбол:

$$Mt = 1122.33 - 0.4377Y_{t-1}$$

Мөн хэрэглээний ДНБ-ээс хамаарах функцийг олж, тэдгээрийг нэйтгэх замаар бараа үйлчилгээний импорт ба хэрэглээний харилцан хамаарлыг тооцвол:


$$M_t = 180.38 + 0.8019 * C_t \quad \text{гэсэн функцийн илэрхийлэгдэж байна.}$$

Дээрх функцийн юуг өгүүлж байна вэ гэвэл, хэрэглээ 1.0% өсвөл импорт түүний 80.19%-тай тэнцэх хэмжээгээр дагалдан өсдөг болохыг харуулж байна. Тэгвэл импортын өсөлтийн дөнгөж 19.81% нь хөрөнгө оруулалт ба реэксportын өсөлттэй холбоотой юм байна.

Монгол улсын импортын өсөлтийн дийлэнх хэсэг нь хэрэглээний өсөлттэй холбоотой байгаа ба хөрөнгө оруулалт нь экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэх өнөөгийн шаардлагад нийцэхгүй байна. Хөрөнгө оруулалтын бодит хэмжээ өсөөд байхад экспорт бус харин ДНБ өсөөд байгаа нь Монгол улсад экспортын чиглэлтэй бус харин импортыг орлох чиглэлийн үйлдвэрлэл давамгайлах байдалтайгаар хөгжиж байгааг нотолж байна. Импортын функцийн хэлбэр ч үүнийг бас давхар нотолж байгаа юм. Ийнхүү Монгол улсын экспортын баримжаалалтай үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого нь алдагдаж, импортыг орлох чиглэлээр хөгжиж байна.

Дэлхийн банк улс орнуудыг нэг хүнд ноогдох ҮНБ-ий хэмжээгээр нь өндөр орлоготой орнууд, дундаас дээш орлоготой орнууд, дундаас доош орлоготой орнууд, бага орлоготой орнууд гэсэн 4 ангилалд хуваан авч үздэг. Үндэсний статистикийн газраас гаргасан албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн тооцоолол хийж үзвэл Монгол улс дээрх 4 ангилын дөрөвдүгээрт хамаарч байгаа юм. Экспортын өсөлтийн сүүлийн 5 жилийн чиг хандлагыг ойрын ирээдүйд хэвээр хадгалагдана гэж үзээд гадаад худалдааны үргүүлэгчийн тусламжтайгаар ДНБ-ий өсөлтийн прогнозыг тооцоолбол, 2010 он гэхэд түүний хэмжээ одоогийнхоос 12.4% орчим өссөн байх юм.

Монгол улсын худалдааны болон төлбөрийн тэнцлийн нөхцөл байдал, ДНБ-ий хэмжээ ба өсөлтийн хурдац зэрэг нь бүхэлдээ улс орны эдийн засагт орлогыг бий болгох стратеги бодлогыг шаардаж байгаа юм. Үүнийг схемчлэн харуулбал:



Импортыг орлох чиглэл бүхий үйлдвэрлэл хөгжиж байгаагийн учир шалтгаан нь юунд оршиж байна вэ? Импортыг орлох таваарын үйлдвэрлэл төлбөрийн тэнцлийг сайжруулахад бас л чухал үүрэгтэй шүү дээ. Тэгвэл яагаад экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогод түүнээс илүү ач холбогдол өгөөд байгаа юм бэ гэсэн асуултууд тавигдах нь зайлшгүй.

Рыбчинскийн теоремд зааснаар "Үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн нийлүүлэлтийн өсөлт нь тэдгээрийг илүү эрчимтэй ашигладаг тэрхүү салбарын үйлдвэрлэлт болон орлогыг пропорциональ бус их хэмжээгээр нэмэгдүүлэхэд хүргэнэ, тэдгээрийг харьцангуй бага хэрэглэдэг салбарын үйлдвэрлэл борлуулалтыг бууруулдаг". Үүнийг ухаж ойлговол өнөөдрийн импортыг орлох салбарын хөгжилт нь улс орны дотоодын зах зээл дэх үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн эрэлт нийлүүлэлтийн тэнцвэртэй холбоотой юм байна. Дотоодын зах зээлд хөдөлмөр, газар зэрэг үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн нийлүүлэлт их байгаа учраас тэдгээрт түшиглэсэн импортыг орлох салбарууд эрчимтэй хөгжиж байна.

Экспортыг баримжаалсан бодлогын нь давуу тал нь дараах үндэслэлүүдээр тайлбарлагдаж байна.

Үүнд:

- Монгол орон үндэсний үйлдвэрлэлийнхээ үнэмлэхүй ба харьцангуй давуу талыг агуулсан бараа бүтээгдэхүүнийг экспортлож, экспортын орлогоороо дотооддоо үйлдвэрлэх боломжгүй бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, эдийн засгийн үр ашиг олох, дэлхийн улс орнуудын хөгжлийн ололтыг хуваалцах замаар дэлхий дахинь эдийн засгийн интеграцид улам бүр идэвхтэй оролцож, эдийн засгийнхаа хөгжил дэвшилийг түргэтгэж чадна.
- Экспортыг дэмжнээр төлбөрийн тэнцлээ сайжруулж, ҮНБ-ээ өсгөж чадна. Экспорт дэмжих нь үндэсний үйлдвэрлэлийг, үндэсний эдийн засгийг орлогын хомсдоос гаргах үндсэн арга зам мөн.
- Экспортыг дэмжнээр ажилгүйдлийг бууруулах, хүн амын орлогыг нэмэгдүүлэх г.м нийгмийн шинжтэй олон асуудлыг шийдвэрлэж, дээрх зориулалтаар зарцуулагдаж буй төсвийн зарлагыг бууруулж чадна. Экспортлогчдоос хураан авах татвар нь төсвийн орлогын нэг чухал эх үүсвэр мөн.
- Экспортыг дэмжнээр үндэсний үйлдвэрлэлийн өртөг бүтээх шат дамжлагын тоо олширч, эцсийн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэнэ.

Экспортыг дэмжих үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлснээр бусад улс орнуудаас эдийн засгийн хараат байдлаа багасгаж, үндэсний аюулгүй байдлын хүрээнд тавигдаж буй зарим зорилтуудыг хэрэгжүүлэх боломжийг олж авч чадна. Харин импортыг орлох салбаруудын хувьд дээрх боломжууд хязгаарлагдмал байдаг.

Самуэльсон-Жонсын теоремд зааснаар “олон улсын худалдаанд оролцсны дунд экспортын салбар дахь үйлдвэрлэлийн тусгай хүчин зүйлсийг эзэмшигчдийн орлого нэмэгдэж, импорттой өрсөлдөх салбарын хувьд тэрхүү орлого буурах хандлагатай”. Пол Самуэльсон, Рональд Жонс нарын баталсан дээрх теоремын дагуу авч үзвэл импортыг орлох үйлдвэрлэлийн өсөлт нь урт хугацаанд Монгол улсын эдийн засагт шаардагдаж буй тэр орлогыг бий болгох арга зам хараахан биш байна.

Экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн нийлүүлэлтийг, түүний дотор одоогийн нөхцөлд нэн чухал шаардлагатай техник технологийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нь чухал байна. Эдгээрийг улс орны дотоодод үйлдвэрлэдэггүй тул түүнийг олж авах гол арга замууд нь импорт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, донор орнуудын техникийн туслалцаа юм. Эдгээрээс засгийн газрын шууд хяналтад байдаг, төрөөс зохицуулах боломжтой хэлбэр нь техник технологийн импорт юм. Энэ утгаараа “экспортыг баримжаалсан бодлого” нь экспортын төдийгүй импортын зохицуулалтыг шаардаж байгаа юм.

Импортын бүтцэд экспортын үйлдвэрлэлд шаардагдаж буй техник тоног төхөөрөмжийн эзлэх хувийн жин нэмэгдэж байгаа боловч шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна. Импортын иймэрхүү бүтэцтэйгээр ойрын ирээдүйд эдийн засгийг сэргээн босгох боломжгүй. Экспортыг дэмжих төрийн бодлого нь экспорт импортын зохисгүй бүтцийг өөрчлөх, цөөхөн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс улс орны худалдааны нөхцөл, төлбөрийн тэнцэл, цаашилбал улс орны эдийн засаг нь хамаардаг одоогийн тогтолцоог өөрчлөхөд чиглэх ёстой.

Бидний өгүүлийн гол зорилт нь ямар нэгэн асуудлыг шийдвэрлэхэд чиглэж байгаа бус, харин Монгол УИХ-аас баталсан “экспортын баримжаатай эдийн засаг”-ийг хөгжүүлэх зорилт ямар байдалд орсон бэ гэдгийг харуулахад оршиж байгаа юм.